

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоод зохион байгуулалтын арга хэмжээ

Компанийн mtz.mn цахим хуудсанд “Авлигын эсрэг үйл ажиллагаа” булангийн “Авлигын хууль тогтоомж” дэд буланд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтмол байршуулан, мэдээллийн санг баяжуулж хууль тогтоомжийг нийтэд сурталчилж байна.

Компанийн docs.mtz.mn дотоод сүлжээний “Хэрэгцээт файлууд” санд холбогдох ном, гарын авлага, мэдүүлэг, мэдэгдэл, баталгааны маягтууд, аргачлал, зөвлөмжийг байршуулж, ийнхүү байршуулсан мэдээллийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах талаар цахим шуудангаар нийт хамт олонд мэдэгдэх зэргээр компанийн дотоод үйл ажиллагаанд хууль тогтоомжийг таниулах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч байна.

“Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дүгээр тушаал, “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгах тухай” Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Гүйцэтгэх захирлын 2020 оны 08 дугаар тушаалаар батлуулав.

Мөн энэхүү тушаалаар “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хуудас”, “Ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбарын бүртгэлийн хуудас”, “Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгааны хуудас”-ны загварыг тус тус баталсан.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар тус компанийн Захиргаа, удирдлага, инженер, техникийн ажилтнуудын дунд тодорхой сэдэв, давтамжтайгаар сургалт зохион байгуулах хүсэлтийг 2020.01.08 өдрийн 01/32 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлэв.

АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2020 оны 3 дугаар сард багтаан сургалт зохион байгуулахаар хариу мэдэгдсэний дагуу зохион байгуулахаар төлөвлөсөн нь цар тахлын улмаас хойшлоод байна.

Авлигатай тэмцэх газрын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 04/2610 тоот албан бичгийн дагуу сургалтад хамрагдаагүй, шинээр томилогдсон 11 албан тушаалтны мэдээллийг цахим хэлбэрээр бүртгүүлж, энэ тухай албан бичгээр хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газраас эрх бүхий албан тушаалтнаас цахим хэлбэрээр ХАСХОМ-ын шинэчлэх талаар санал, асуулга авах ажлыг 2020 оны 5 дугаар сарын 14-нд зохион байгуулав.

Компанийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэх захирлаар шийдвэр гаргуулан эрх бүхий албан тушаалтны жагсаалт, ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалтыг шинээр батлуулсан.

2020 оны эхний хагас жилийн байдлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалд нэр дэвшсэн 4 хүний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдох материалын хамт АТГ-аар хянуулж, дүгнэлт гаргуулан Гүйцэтгэх захирлын тушаалаар үүрэгт ажилд нь томилов.

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч 2 хүн ТӨБЗГ-т ХАСУМ гаргаж АТГ-аар хянуулсны дараа ТӨБЗГ -ын тогтоолоор томилогдсон байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд 2020 оны 02 сарын 15-ны байдлаар гаргавал ХАСХОМ-ын мэдүүлэг, 2019 оны зохих тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж холбогдох төрийн байгууллагад хүргүүлж, тайлагнасан.

2020 оны эхний хагас жилийн байдлаар Тус компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшсэн 4 хүний АТГ-ын дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирлын тушаалаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч 2 хүнийг ТӨБЗГ -ын тогтоолоор үүрэгт ажилд нь томилж, хуульд заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргуулав.

Мэдүүлгээ хугацаа хоцроож мэдүүлсэн, гаргасан албан тушаалтан байхгүй.

Компанийн ТУЗ-ийн шийдвэр, үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, Гүйцэтгэх захирлын шийдвэр гаргах ажиллагааны үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхэд хяналт тавих зорилгоор хариуцсан ажилтан болон ЭБАТ хамтран ажиллаж тухай бүр нь албан тушаалтнаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдлийг гаргуулж хэвшсэн.

Түүнчлэн Компанийн албан хэрэг хөтлөлтийн журамд заасны дагуу албан баримт бичгийн төсөлд виз авах саналын хуудасны батлагдсан маягтад "Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх" баганыг оруулж өгснөөр баримт бичиг боловсруулсан болон хянасан бүх албан тушаалтнаас мэдэгдлийг хялбаршуулсан байдлаар гаргуулах ажил хэрэгжиж байна.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 08 дугаар тушаалаар "Ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбарын бүртгэлийн хуудас", "Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгааны хуудас"-ны загварыг тус тус батлуулан ажиллаж байна.

2020 оны эхний хагас жилийн байдлөөр Үнэлгээний хороо, Сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдээс Ашиг сонирхлын зөрчилгүй тухай 210 мэдэгдэл гаргаад байна.